

## ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

*Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар*

Монгол Улсад шүүх дэх эвлэрүүлэн зуучлал болон шүүхээс гадуур бусад байгууллага дахь эвлэрүүлэн зуучлал байх холимог тогтолцоог 2012 оны Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулиар хуульчилсан боловч хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгаагаар<sup>1</sup> шүүх дэх эвлэрүүлэн зуучлал амжилттай хэрэгжиж байгаа талаар дүгнээд, тус хуулийн хэрэгжилтийн гол цөм нь шүүх дэх эвлэрүүлэн зуучлалыг бэхжүүлэх, сайжруулахад чиглэгдсэн байна хэмээн дүгнэсэн байна.

Тухайлбал шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагааны статистик тоон мэдээллээс үзвэл 2014 оноос 2020 оныг хүртэлх 6 жилийн хугацаанд нийт 223,468 иргэний хэргээс 47,587 хэрэг буюу дунджаар нийт иргэний хэргийн 17.2 хувийг эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар амжилттай шийдвэрлэсэн бөгөөд энэ нь иргэний хэргийн шүүхийн ачааллыг тэр хувиар багасгаж буй ач холбогдолтой юм.<sup>2</sup>

Харин шүүхээс гадуурх төрийн болон төрийн бус мэргэжлийн холбоод дахь эвлэрүүлэн зуучлалын бодит хэрэгжилт хангалтгүй түвшинд байгаа бөгөөд үүний учир нь төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод эвлэрүүлэн зуучлагч ажиллаж, талуудын маргааныг амжилттай шийдвэрлэсэн ч тус эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулдаггүй нь тухайн маргаанаар дахин шүүхэд хандах нэмэлт зардал үүсэх, цаг хугацаа алдах зэрэг сөрөг нөлөөллийг үзүүлж байсантай холбоотой гэжээ.<sup>3</sup> Үүнээс үзвэл Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан төрийн болон төрийн бус байгууллага дахь эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хэрэгжилт зохих түвшинд хүрч чадаагүй байна.

Иймд хуулийн төслөөр шүүхийн бус (арилжааны эвлэрүүлэн зуучлал) эвлэрүүлэн зуучлалыг бэхжүүлэх, амилуулах, маргаан шийдвэрлэх сонголттой хувилбарыг бий болгохын тулд дараах зарчмын шинжтэй өөрчлөлтүүдийг хуулийн төслөөр оруулж өгсөн болно. Үүнд:

- Шүүхийн бус эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дүнд байгуулсан эвлэрлийн гэрээг шүүгчээр баталгаажуулдаг болох, улмаар шүүгчээр баталгаажуулсан эвлэрлийн гэрээний үүрэг зөрчигдөхөд албадан гүйцэтгэх боломжийг нь нээж өгсөн;

- Шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалын үр дүнд байгуулсан эвлэрлийн гэрээ нь заавал биелэгдэх шинжтэй, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах үндэслэл болж байгаа тул шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, хяналт, зохицуулалтыг бий болгох зорилгоор эвлэрүүлэн зуучлах төвийг магадлан итгэмжлэх тогтолцоог шинээр бий болгож өгсөн;

- Мөн шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалын зохицуулалтын тогтолцоог дэлхийн

<sup>1</sup> Үүнээс дурьдвал Япон Улсын Олон Улсын Хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА) болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн захиалгаар “Монголын хууль тогтоомжийн нийгэмлэг” ТББ нь 2015 болон 2020 онуудад хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгаа

<sup>2</sup> Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тойм”, Шүүх эрх мэдэл сэтгүүл №2, 2020 он., 128 дахь тал.

<sup>3</sup> JICA, Шүүхийн ерөнхий зөвлөл “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгаа”, УБ 2020 он., 84 дэх тал.

бусад улсуудын нэгэн адил хууль зүйн яам магадлан итгэмжлэх, зөвшөөрөл, олгох, бэлтгэх, давтан сургах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг байхаар хуулийн төсөлд тусгаж өгсөн. Ингэхдээ, одоо амжилттай хэрэгжиж байгаа шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалыг хэвээр хадгалах байдлаар хуулийн төсөлд тусгаж өгсөн;

- Шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалыг явуулахдаа эвлэрүүлэн зуучлалын төвөөр дамжуулж явуулах бөгөөд эвлэрүүлэн зуучлах төвд тавигдах шаардлагуудыг төсөлд тусгаж өгсөн;

- Түүнчлэн, эвлэрүүлэн зуучлалд хандаж маргаанаа шийдвэрлүүлэх хөшүүргүүдийг төсөлд тусгаж өгсөн. Тухайлбал, банк болон банк бус санхүүгийн байгууллагаас олгосон зээл, түрээс, эд хөрөнгө хөлслөх гэрээ зэрэг талууд эвлэрэх магадлал өндөр маргаануудад эвлэрүүлэн зуучлалд хандах урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмыг тогтоож өгсөн. Мөн эхний уулзалтыг заавал хийх, талууд өөрсдөө эвлэрүүлэн зуучлалд хандаж маргаанаа шийдвэрлүүлэхээр өргөдөл гаргасан боловч эвлэрэл амжилтгүй болсон бол шүүхийн тэмдэгтийн хураамжаас хөнгөлөх зэрэг эвлэрүүлэн зуучлалд хандах хөшүүрэг болсон зохицуулалтыг оруулж өгсөн;

- Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны нууцлалын зохицуулалтуудыг боловсронгуй болгож, олон улсын жишигт нийцүүлэх байдлаар тусгаж өгсөн.

Хуулийн төслийг Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгаа, хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлагын урьдчилсан тандан судалгаанд үндэслэн боловсруулсан бөгөөд Олон Улсын Эрх зүйн хөгжлийн байгууллага (IDLO), Европын сэргээн босголт, хөгжлийн банк (EBRD) зэрэг олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр гадаад болон дотоодын Зөвлөхүүдийн саналд тулгуурлан боловсруулж, хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу үр нөлөөний судалгаа болон хуулийн төслийн зардлын тооцооны судалгааг гүйцэтгэсэн болно.

Түүнчлэн, хуулийн төслийг боловсруулахдаа бусад улс орны туршлагыг судалсан бөгөөд ингэхдээ тухайлсан нэг улсыг судлалгүй эвлэрүүлэн зуучлалын зохицуулалтын байгууллага, эвлэрлийн гэрээг баталгаажуулах арга зам, эвлэрүүлэн зуучлах төвийг магадлан итгэмжлэх тогтолцоо, эвлэрүүлэн зуучлагчид тавигдах шаардлага, эвлэрүүлэн зуучлалыг идэвхжүүлэх эрх зүйн зохицуулалт зэрэг тодорхой асуудлуудаар олон улсын болоод бусад улс орны сайн туршлагыг харьцуулан, хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаагаар авч үзсэн болно.